

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас. 2018 оны 10 сарын дугаар.

Тэргүүн Мэдээ

ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал боловсруулав.



Японд сургалтын хөтөлбөрийг 10 жил тутам шинэчилдэг бол Монголд 4 жил тутамд буюу маш богино циклээр шинэчилж ирсэн байна. Богино циклтэй хөтөлбөрийн шинэчлэл нь боловсролын байгууллагуудын нягт хамтын ажиллагааг сулруулж, сургалтын хөтөлбөрийг шинэчлэлийн явцад шаардлагатай “Хөтөлбөрийн шинэчлэл”, “Сурах бичиг зохиох”, “Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэмжлэг”, “Боловсролын үнэлгээ” зэргийг шинэчлэх, менежментийн чанарыг хадгалахад үе шат бүрт хүндрэлтэй байв. Иймд ТХА-ны “Суралцахуйг дэмжих мэргэжлийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх төсөл (PROCESS)”-р Японы жишээнээс санаа аван 10 жилд 1 удаа бага дунд боловсролын хөтөлбөрийг шинэчлэх процессийг “ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал” гэж нэрлэн, хэрэгжүүлэх аргачлалыг боловсруулж, БСШУСЯ-аар батлуулсан юм. Монгол улс энэхүү арга хэмжээнд ихээхэн анхаарал хандуулан хэвлэл мэдээллийн хэргэслээр сурталчилав. Энэ ажилд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн PROCESS төслийн мэргэжилтэн Фукуо Томохирог Монгол улсын боловсролын тэргүүний ажилтан цол тэмдэгээр шагнасан байна.

Төслийн хэрэгжилт

Орхон аймагт Монгол улсад анх удаа төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн (Ерөнхий мэргэшил судлал) сургалтыг хэрэгжүүлж эхэллээ.



10 сарын 22-ны өдөр ТХА-ны “Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Монгол улсад анх удаа Орхон аймгийн Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төвд Анагаахын их сургууль төгссөн эмч нарт чиглэсэн үндсэн мэргэшлийн (Ерөнхий мэргэшил судлал) сургалтыг эхлүүллээ. ЭМЯ-аас БОЭТ-д орон нутагт тус сургалтыг эрхлэх зөвшөөрлийг анх удаа олгосон ба Япон улсын тогтолцоог жишиг болгон суралцагч эмч нарыг эмч болоход шаардлагатай үндсэн суурь бүрдүүлэхэд удирдан чиглүүлэн ажиллана. Энэхүү сургалт нь орон нутагт эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэх загвар болно гэдэгт найдаж байна.

Дизель хөдөлгүүрт тээврийн хэрэгслийг зохицуулахтай холбогдуулан Токио хотын туршлагаас хуваалцах семинар зохион байгуулав.



10 сарын 16-ны өдөр ЗТХЯ, НЗДТГ, ЖАЙКА хамтран УБ хотод хэрэгжүүлэх дизель тээврийн хэрэгслийг зохицуулах журамтай холбогдуулан семинар зохион байгуулж, Токио хотод дизель тээврийн хэрэгслийн талаар авч хэрэгжүүлсэн бодит арга хэмжээний жишээг танилцуулав. Улаанбаатар хотод 2019 оны 5 сараас дизель тээврийн хэрэгслийг зохицуулахаар төлөвлөж байгаа бөгөөд семинарт оролцогчид Токио хотын захиргаа, Японы засгийн газартай хамтран нэвтрүүлсэн урамшууллын бодлого, торгуулийн арга хэмжээ, зохицуулалтын журам хэрэгжүүлж эхлэх хүртэл шаардагдсан бэлтгэл хугацаа зэрэг олон асуулт асуув. Цаашид Токио хотын туршлага болон одоо хэрэгжиж буй “Улаанбаатар хотын Нийтийн тээврийн автобусны дизель хөдөлгүүрт DPF (Diesel Particulate Filter) тортог шүүгчийг суурилуулж хөдөлгүүрээс ялгарах тортогжилтыг бууруулах туршилтын төсөл”-ийн мэргэжилтэний зөвлөгөө Улаанбаатар хотод дизель тээврийн хэрэгслийн зохицуулалт хийхэд нэмэр болно гэж найдаж байна.

Улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн чадавхи бэхжүүлэх төслийг хэрэгжүүлэх чиглэлийн талаар тохиролцов.



10 сарын 5-ны өдөр ҮХГ, СЯ, ЖАЙКА-нь ТХА-ны “Улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн чадавхи бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх тухай хурлын тэмдэглэлд гарын үсэг зурав. Энэхүү төсөл нь хөгжлийн бодлого ба санхүүжилттэй уялдсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих тогтолцоог бий болгож, боловсон хүчинг сургаж бэлтгэх зорилготой бөгөөд 2019 оны 2 сараас эхлэн 4 жилийн хугацаанд хэрэгжиж, холбогдох байгууллагуудын ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, хөтөлбөрт тусгах төслүүдийн жагсаалтыг гаргах, эрэмбэлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүжилтийн механизмыг бий болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна.

ЖАЙКА “Оюуны болон техникийн хөрөнгө оруулагч байгууллага”-ын өргөмжлөл гардан авлаа.



10-р сарын 5-ны өдөр Монголын багш нарын баяр боллоо. Энэхүү тэмдэглэлт өдрийг тохиолдуулан БСШУСЯ-наас Боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийсэн байгууллагуудыг шагнасны дотор ЖАЙКА “Оюуны болон техникийн хөрөнгө оруулагч байгууллага”-аар шалгаран өргөмжлөл гардан авлаа. ЖАЙКА нь 1990-ээд оноос хойш сургуулийн барилгын төсөл, хүүхэд төвтэй боловсролыг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол зэрэг олон чиглэлээр боловсролын чанарыг дээшлүүлэхэд хүчин зүтгэж ирсэн юм. Шагнал гардуулах ёслол дээр ЖАЙКА-ийн Төлөөлөгчийн газрын дарга Сато Мүцүми талархлаа илэрхийлэхийн ялдамд улсын хөгжилд боловсрол чухал ач холбогдолтой болохыг тэмдэглээд, цаашид Монголын боловсролын салбарын хөгжлийн төлөө хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхээ илэрхийлэв.

Сайн дурын үйл ажиллагаа

Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга

Дорнод аймгийн засаг дарга гадаадын сайн дурын мэргэжилтнүүдтэй санал солилцлоо



2018 оны 10 сарын 7-ны өдөр Дорнод аймгийн засаг даргын санаачлагаар зохион байгуулсан “Засаг дарга ба тус аймагт томилогдон ажиллаж байгаа гадаадын сайн дурын мэргэжилтэн, багш нарын (ЖАЙКА, Peace Corps, KOICA) уулзалт”-д боловсролын чиглэлээр ажиллаж буй ЖАЙКА-ийн 3 сайн дурын гишүүн оролцов. Засаг дарга “Өнгөрсөн 5 жилийн хугацаанд Дорнод аймаг нь сурлагын үзүүлэлтээр улсдаа тэргүүн байранд орж байгаад гадаадын сайн дурын мэргэжилтэнүүдийн тус нэмэр их байгаа” хэмээн талархал илэрхийлж, сайн дурын мэргэжилтнүүдийн санал сэтгэгдлийг цаашид ажил хэрэгтээ тусгаж ажиллахаа мэдэгдэв. ЖАЙКА-ийн хувьд боловсролын салбар дахь сайн дурын хамтын ажиллагаагаа цаашид ч үргэлжлүүлэх болно.

Бусад сайн дурын үйл ажиллагаа

- 10 сарын 17-ны өдөр 2018 оны 2-р ээлжийн 5 сайн дурын гишүүн ирэв. Тэд дараах байгууллагуудад томилогдож, тус тусын ажил мэргэжлээр Монгол улсад 2 жилийн хугацаатай сайн дурын үйл ажиллагаа явуулах юм.

Онодэра Гэн-Жүдо, Монголын Жүдо бөхийн холбоо

Сакурай Хикари-Сагсан бөмбөг, Дархан-Уул аймгийн Биеийн тамир, спортын газар

Окүда Мисаки-Хөдөлмөр засалч, Шастины 3-р төв эмнэлэг

Накамүра Акико-Сувилагч, Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төв

Нагай Айка-Бадминтон, Монголын Бадминтоны холбоо



ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбоо.

ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбоо мод тарих үйл ажиллагаа зохион байгууллаа



10 дугаар сарын 13-ны өдөр ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбоо Улаанбаатар хотын байгаль орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулахын зэрэгцээ холбооны гишүүд хоорондын нөхөрлөл, хамтын ажиллагааг сайжруулах үүднээс Сонгинохайрхан дүүргийн Агропарк мод тарих үйл ажиллагаа зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд холбооны гишүүд болон ЖАЙКА-ийн Төлөөлөгчийн газрын ажилтнууд зэрэг нийт 46 хүн оролцож, мэргэжилтний зааварчилгаан дор Агч, Голт бор зэрэг 7 төрлийн 150 суулгац тарьсан байна. Гэр бүлээ дагуулж ирсэн холбооны гишүүд ч олон байсан бөгөөд бидний хойч ирээдүй болсон хүүхэд багачууд аав ээжтэйгээ хамт мод тарьж, ой мод, байгаль орчны талаарх ойлголт мэдлэгээ гүнзгийрүүлсэн нь чухал ач холбогдолтой байлаа.



Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага.(ЖАЙКА) Монгол дахь төлөөлөгчийн газар.

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс
(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)
Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 Имэйл: mg_oso_rep@jica.go.jp